



2026 оны 06 дугаар
сарын 08-ны өдөр



2026 оны 06 дугаар
сарын 08-ны өдөр

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.5.2-т “Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, чадавхыг бэхжүүлнэ” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилго 7-д “Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана” гэж, 7.3-т “Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.4.14-т “Гамшгийн шуурхай удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулна” гэж, Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.3 дахь хэсгийн 20-д “Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх”-ээр тусгасан нь Гамшгаас хамгаалах

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Дэлхий дахинд улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээний тогтворгүй байдал, техник технологи, хотжилт, үйлдвэржилт, хүн амын төвлөрөл, аюултай бодисын хэрэглээнээс үүдсэн осол, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй төрөл бүрийн гамшиг, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний эрсдэл улам бүр нэмэгдэж байна. Тухайлбал, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн тоо 2016 онтой харьцуулахад 2025 онд 2.4 дахин нэмэгдсэн. 2016-2025 онд нийт 45446 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 4338 хүн /ковид-19 цар тахлын үед 1815/ амь насаа алдаж, 991194 хүн /ковид-19 цар тахлын үед 989816/ өвчилж, гэмтэж бэртэн, 11.3 сая толгой мал, амьтан хорогдож, 1.9 их наяд төгрөгийн шууд хохирол учирсан.

Иймд гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлан явуулах, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, салбар дундын харилцан ажиллагаа, удирдлага, зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, гамшгийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хохирол, хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар аливаа гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхтай нийгмийг төлөвшүүлж, гамшгийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ, шаардлага улам бүр чухлаар тавигдаж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2025 онд хийсэн “Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”-ийн дүгнэлт, санал, зөвлөмжид дараах асуудлыг анхаарах шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

- Хуулийн нэр томьёоны тодорхойлолтууд олон улсын баримт бичиг, стандартад зарим талаар нийцээгүй, үндэсний бусад хууль, тогтоомжтой уялдаагүй, зарим нэр томьёог тодорхойлоогүй, гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалтад эрх, үүргийн давхардал, хийдэл бүхий уялдаа холбоогүй зохицуулалт байгаагаас гадна зарим үйл ажиллагаа хуулиар бус, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж байгаа нь хууль зүйн эрэмбэ дараа алдагдаж, хуулийн хэрэгжилтийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Иймд хууль зүйн техник, хууль хоорондын уялдаа холбоо, ойлгомжтой байдлыг хангах, хууль зүйн нэр томьёог нэг мөр болгох, эрх зүйн давхардал, хийдлийг арилгахын тулд тус хуульд заасан зарим нэр томьёог өөрчлөх, шаардлагатай нэр томьёог нэмж тусгах;

- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх үндэслэл, нэн ялангуяа бүх нийтийн бэлэн байдалд хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхойгүй, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал, улсын хяналтын хамрах хүрээ оновчтой бус байгааг тодорхой болгох, хуулийн этгээд нэг бүр гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, мэргэжлийн ангитай байх зохицуулалтыг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны онцлог, чиглэл, ажиллах хүчний тоо, хэрэгцээ шаардлагыг харгалзан практикт нийцүүлж өөрчлөх;

- Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгох, үнэлгээний гүйцэтгэл, тайланд хяналт тавих, гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг

боловсронгуй болгож, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллага, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэхэд анхаарах;

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тэдгээрийн удирдлага, иргэд, олон нийт, сайн дурынхан, хувийн хэвшлийн оролцоо, хариуцлагыг илүү тодорхой болгох;

Гамшгийн үед хүний эрхийг хамгаалах зарчмыг тусгайлан бэхжүүлж, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, асран хамгаалалт шаардлагатай хүн, нийгмийн халамж, хамгааллын дэмжлэг шаардлагатай өрх, иргэн зэрэг онцгой хэрэгцээ, дэмжлэг шаардлагатай бүлэгт мэдээлэл, сэрэмжлүүлэг, нүүлгэн шилжүүлэлт, түр байр, эрүүл мэндийн тусламж, аюулгүй байдлын үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, ялгаварлалгүй хүргэх зохицуулалтыг боловсронгуй болгох;

- Гамшгийн үед иргэдийг сайн дурын үндсэн дээр татан оролцуулах журам, эрх, үүрэг, чиг үүрэг, тэдгээрийг хүлээн зөвшөөрөх, бүртгэх, сургах, удирдан зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

- Гамшгийн эрсдэл, хохирлыг хуваарилах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын даатгалын хамгаалалтыг өргөжүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирол барагдуулах үйл ажиллагаанд даатгалын компанийг оролцуулах, гамшгийн эрсдэлийн даатгалын төрөл, нөхцөлийг хөгжүүлэх, төр, хувийн хэвшил, даатгалын байгууллага хоорондын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсонтой холбогдуулан цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахтай холбоотой асуудлыг холбогдох хуулиар зохицуулах, түүнчлэн цар тахлын үед буюу 2020-2021 онд Гамшгаас хамгаалах тухай хуульд оруулсан 5 удаагийн нэмэлт, өөрчлөлтийн улмаас үүссэн удирдлагын эрх, үүргийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;

- Анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлсэн үед болон энгийн үед иргэдийн хайхрамжгүй байдлаас үүдэн гарсан дуудлага, мэдээлэл нь онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд ачаалал үүсгэж, хариу арга хэмжээний үндсэн чиг үүргээс хазайх, санхүүгийн үр ашиггүй байдлыг нэмэгдүүлэх зэрэг хүндрэл, бэрхшээл дагуулж байгаа тул энэхүү асуудлыг эрх зүйн арга хэрэгслээр зохицуулах;

- Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал, эрх, үүрэг, нийгмийн баталгаа, удирдах албан тушаалтны бүрэн эрх, хариуцлагын талаарх зохицуулалтыг оновчтой болгох, хэрэгжилтийг хангах механизмыг цогцоор нь бүрдүүлэх, хийдэл, зөрчлийг арилгах замаар тус байгууллагын мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зарчим, эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлэх¹;

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа зохион байгуулах, мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагаар хангах, онцгой байдлын байгууллага чиг үүргээ

¹ Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, 193-206 дэх тал

үндэсний хэмжээнд зүй зохистой хэрэгжүүлэх чадавхтай байх, хүний нөөц, техник хэрэгсэл зэрэг бүх талын нөөц бүрдүүлэх хэрэгцээ, шаардлагыг хангахад санхүүжилт ихээхэн шаардагдах тул гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, онцгой байдлын байгууллагын онцлогийг харгалзан төсөв, хөрөнгө хуваарилах, санхүүжилтийн олон талт хэлбэрийг бүрдүүлэх, зарцуулалтыг хянах эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай гэж үзсэн.

Мөн Гамшгаас хамгаалах тухай хуулийг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх, үндэсний хууль тогтоомжийн нийцэл, уялдаа холбоог сайжруулах, хуулийн бүтэц, хэлбэр, хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагаас гадна агуулгад тавигдах нийтлэг шаардлага, тухайлбал: "Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх; тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх; хуулийн зүйл, хэсэг, заалтууд хоорондоо зөрчилгүй байх; тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх шаардлага"-д нийцүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн байна гэж дүгнэсэн².

Монгол Улсын 330 сумын 250 суманд Онцгой байдлын байгууллагын гал түймэр унтраах, аврах салбар нэгж байхгүйгээс тухайн сумдад гарсан гал түймэр, гамшиг, осол үед онцгой байдлын байгууллага шуурхай хүрч ажиллахад хүндрэл үүсэж, гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээ иргэд, аж ахуйн нэгж байгууллагад тэгш, хүртээмжтэй хүрч чадахгүй нөхцөл үүсдэг. Иймд онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй суманд 1 алба хаагчийн орон тоог бий болгож, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа явуулах, бэлэн байдлыг хангуулах, эрэн хайх, аврах ажиллагаа, иргэд, сайн дурынхан, сумдын мэргэжлийн ангийг удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүрэгтэй ажиллуулах хэрэгцээ шаардлага тулгарч байна. Ингэснээр суманд онцгой байдлын байгууллагын анги, салбар байгуулснаас хэдэн арав дахин бага зардал гарах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэд, олон нийт, сайн дурынхны оролцоо нэмэгдэх, сум орон нутгийн гамшгаас хамгаалах бэлэн байдал сайжирч, гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэх ач холбогдолтой юм.

Манай улсад гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, тэр дундаа гамшгийн хохирлыг арилгах үйл ажиллагааг дан улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаа нь томоохон хэмжээний гамшиг тохиолдсон үед төсөвт ирэх ачааллыг эрс нэмэгдүүлж байна. Иймд олон улсын жишигт нийцүүлэн гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсвөөс гадна зээл, тусламж, даатгал, бонд зэрэг бусад эх үүсвэрээс бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ, шаардлага байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тодорхой хувь хэмжээгээр хөрөнгө төсөвлөн зарцуулахаар заасан боловч уг зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг төвлөрүүлэх, хуримтлуулах төсвийн ангилал

² Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, 208-209 дэх тал

байхгүйгээс хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна. Үүний улмаас тухайн төсвийг орон нутагт төвлөрүүлж буй хэлбэр харилцан адилгүй, Засаг даргын нөөц хөрөнгөөр орлуулах, гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд түлхүү зарцуулах хандлага түгээмэл байгаагаас гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд чиглэсэн тогтвортой санхүүжилт бүрдэхгүй байна. Түүнчлэн, 2026 оны байдлаар орон нутгууд дунджаар төсвийнхөө 1.0-ээс доошгүй хувийг бус ойролцоогоор 0.5 хувийг тусган хэрэгжүүлж байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд аймаг, нийслэл, сум, дүүрэг нь гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны санхүүжилтийг тусгайлан төвлөрүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, хуримтлуулах зорилгоор “Гамшгийн эрсдэлийг бууруулах сан”-тай байх зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилго нь гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалтыг боловсронгуй болгох, гамшгаас хамгаалах төлөвлөлт, сургалт, бэлэн байдал, хяналт, санхүүжилтын тогтолцоог сайжруулах, гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, бүх нийтийн оролцоог хангах замаар хуулийн хэрэгжилттэй холбоотой практикт гарч буй бэрхшээл, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулахад чиглэнэ.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль³-ийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төслийн бүтэц 7 зүйлтэй байх бөгөөд зарим хэсэг, заалтыг шинээр нэмэх, өөрчлөн найруулах, нэмэлт оруулах, өөрчлөх, хасах, хүчингүй болгох, хуулийг дагаж мөрдөх хугацаа гэсэн бүтэцтэй байна. Уг хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

1/ зарим нэр томъёоны тодорхойлолтыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх, товч тодорхой, ойлгомжтой болгож, шаардлагатай нэр томъёог шинээр нэмж тодорхойлно;

2/ гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдийг олон улсын жишигт нийцүүлэн бүх нийтийн бэлэн байдлын зэргийг хасаж, байнгын бэлэн байдал, өндөржүүлсэн бэлэн байдлын гэсэн хоёр зэрэгтэй болгож, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх үндэслэл, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгоно;

3/ гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцооны давхардал, хийдлийг арилгаж, удирдлага, байгууллага хоорондын чиг үүргийн уялдаа холбоог оновчтой болгон, хуульчлах шаардлагагүй зохицуулалтыг хасаж, хуульчлах шаардлагатай, журмаар зохицуулж байгаа асуудлыг хуульд тусгана;

³ 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Хууль тогтоомжийн тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

4/ гамшгаас хамгаалах сургалт, мэдээлэл, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллага, сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийн үнэлгээний тусгай зөвшөөрөл, түүний хэрэгжилт, хяналттай холбоотой чиг үүргийг засаг захиргааны нэгж, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хуулийн этгээдээр тухайлбал төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ;

5/ гамшгийн үед нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээ авах асуудлыг Засгийн газрын бүрэн эрхэд тусгаж, гамшгаас хамгаалах дайчилгаа, төлөвлөлт, бэлтгэл, бэлэн байдал, нөөц хангамж, хариуцлагын тогтолцоог оновчтой болгоно;

6/ онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг нэмж тусгана;

7/ гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах зорилгоор онцгой байдлын байгууллагын салбар нэгжгүй суманд онцгой байдлын байгууллагын мэргэжлийн алба хаагчийг ажиллуулах, томоохон аж ахуйн нэгжид гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан, улсын онц чухал болон стратегийн зориулалттай төрийн өмчит үйлдвэрийн газарт гэрээт нэгж болон байцаагчийг ажиллуулах асуудлыг тусгана;

8/ төрөөс гарч буй үргүй зардлыг багасгах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор гамшиг ослын шинжгүй дуудлагаар ажиллахад гарсан зардлыг дуудлага өгсөн иргэн, хуулийн этгээд хариуцах зохицуулалтыг нэмж тусган тусгана;

9/ гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд чиглэсэн санхүүжилтийг тусгайлан төвлөрүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, хуримтлуулах зорилгоор аймаг, сум, нийслэл, дүүрэгт “Гамшгийн эрсдэлийг бууруулах сан” байгуулах, түүний эх үүсвэр, зарцуулалт, хяналтын зохицуулалтыг хуульд тусгана;

10/ үндэсний хууль тогтоомжийн нийцэл, уялдаа холбоог сайжруулах олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх, зарим зүйл, хэсэг, заалтын уялдаа холбоог хангах, утга агуулгын хувьд оновчтой болгох, нэг мөр ойлгож хэрэглэх үүднээс нэмэлт оруулж, өөрчлөн найруулж, шаардлагагүй хэсэг, заалтыг хасна;

11/ гамшгийн үед хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалах, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, нийгмийн халамж, хамгааллын дэмжлэг шаардлагатай иргэдэд төрийн үйлчилгээг ялгаварлахгүй, тэгш, хүртээмжтэй хүргэх зарчмыг тусгана;

12/ гамшгийн үед иргэдийг сайн дурын үндсэн дээр татан оролцуулах, сайн дурынхныг бүртгэх, сургах, удирдан зохион байгуулах журам, тэдгээрийн эрх, үүрэг, чиг үүрэг зохицуулалтыг тусгана;

13/ гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирлыг барагдуулах үйл ажиллагаанд даатгалын компанийн оролцоог хангах, гамшгийн

эрсдэлийн даатгалын төрөл, нөхцөлийг хөгжүүлэх, төр, хувийн хэвшил, даатгалын байгууллага хоорондын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тусгана;

14/ хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн дараах үр дагавар гарна:

1/ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 36 хүртэлх хувьд нэмэлт, өөрчлөлт орно;

2/ Хуулийн нэр томъёоны тодорхойлолтууд товч тодорхой, ойлгомжтой болж, эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоо, хууль тогтоомжийн нийцэл, хэрэглээний тогтвортой байдал хангагдана.

3/ Гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалтын давхардал, хийдэл арилж, гамшигтай тэмцэх, шуурхай хариу арга хэмжээ авах, хор уршгийг арилгах нэгдсэн зохион байгуулалт, салбар дундын зохицуулалт сайжирч, гамшгийн улмаас нийгэм, эдийн засагт учрах хохирол буурна;

4/ Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх үндэслэл, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, мөрдвөл зохих хэм хэмжээ тодорхой болж, төрөөс авч хэрэгжүүлэх зохицуулалт, зохион байгуулалтын хүндрэл, бэрхшээл арилна.

5/ Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сум бүрд онцгой байдлын байгууллагын 1 алба хаагч, улсын онц чухал болон стратегийн зориулалттай төрийн өмчит үйлдвэрийн газарт гал унтраах, аврах нэгж болон байцаагч гэрээгээр ажилласнаар тухайн орон нутаг, байгууллагын гамшгаас хамгаалах удирдлага зохицуулалт, төлөвлөлт, бэлэн байдал, сургалт, сурталчилгааны үр дүн сайжирч, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоо нэмэгдэж, гамшгийн эрсдэл буурна;

6/ Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсвөөс гадна олон улсын зээл, буцалтгүй тусламж, даатгал, бонд зэрэг олон эх үүсвэрээс бүрдүүлж, зарцуулалтад тавих хяналтын тогтолцоог сайжруулснаар гамшгийн улмаас улсын төсөвт ирэх ачаалал багасаж, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

7/ Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах сан бий болсноор гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг бие даан хэрэгжүүлэх санхүүгийн боломж бүрдэхээс гадна хуримтлал бий болгож дунд болон урт хугацаанд гамшгийн эрсдэлийг бууруулахад хөрөнгө оруулалт хийх нөхцөл бүрдэнэ. Орон нутагт гамшгийн эрсдэлийг бууруулснаар хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагын гамшигт өртөх байдал, гамшгаас учрах хохирол буурч, улсын болон орон нутгийн төсөвт гамшгийн хор уршгийг арилгахтай холбоотой үүсэх гэнэтийн ачаалал багасна.

8/ Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын үүрэг, хариуцлага, оновчтой болж, төр хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын хамтын ажиллагаа сайжирч, иргэд, олон нийтийн оролцоо нэмэгдэж гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал дээшилж, бүх нийтийн оролцоонд тулгуурласан гамшгийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавх бүхий гамшгаас хамгаалах тогтолцоо бүрдэнэ.

9/ Гамшгийн үед хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалах, эмзэг бүлгийн иргэдийн онцлог хэрэгцээг харгалзан үзэх, гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд ялгаварлахгүй, тэгш, хүртээмжтэй хүргэх эрх зүйн орчин бүрдэж, олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлсэн гамшгаас хамгаалах тогтолцоо төлөвшинө.

10/ Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурын үндсэн дээр оролцох иргэдийг бүртгэх, сургах, татан оролцуулах нэгдсэн журам, сайн дурынхны эрх, үүрэг, нийгмийн баталгаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын зохицуулалт тодорхой болсноор олон нийтийн идэвхтэй оролцоо бэхжиж, орон нутгийн түвшинд гамшгаас хамгаалах нэгдсэн хүчин чадал нэмэгдэнэ.

11/ Гамшгийн эрсдэлийг даатгалын механизмаар хуваарилах эрх зүйн орчин бүрдэж, даатгалын компани гамшгаас хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирол барагдуулах үйл ажиллагаанд оролцох нөхцөл бүрдсэнээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас үүдэлтэй хохирлыг нөхөн төлөх төрөл, эх үүсвэр олширч, улсын болон орон нутгийн төсвийн ачаалал багасан, даатгалын зах зээл хөгжих эерэг нөлөөтэй болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Галын аюулгүй байдлын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг тус тус дагалдуулан боловсруулна.

---oOo---